



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/153

Номгон

「Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын
Хангайн бүсийн алба хаагчдын бие бялдрыг
хөгжүүлэх сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2025 оны 01/452 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хангайн бүсийн алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 15,000.000 (Арван таван) сая/төг-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Сургалтын үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж, тайлан мэдээллийг ирүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа (Д.Батгэрэл)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН